



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТШЗ

<b>Цахим хуудас:</b> <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 99177546      Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn	
Аудитор	
Утас: 70484030      Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 57  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БАЯН-УУЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ч.БОЛДБАЯР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 3.3 сая төгрөгөөр тавилга бэлтгэсэн, үндэслэлгүйгээр 30 толгой 2.4 сая төгрөгийн мал данснаас хассан, жилийн эцсийн тооллогоор түлш шатах тослох материал тоолж баталгаажуулаагүй, татварын тодорхойлолтоор 120.4 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 14.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

070 05330

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	272,413,882.32	245,977,979.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	0.00
31210	Төгрөг	-	0.00
31211	Төрийн сангийн харилцах	-	0.00
33	АВЛАГА	11,254,794.00	2,835,447.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	8,000,000.00	2,835,447.00
33500	Бусад авлага	3,254,794.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,254,794.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	229,159,088.32	243,142,532.50
35400	Хангамжийн материал	229,159,088.32	243,142,532.50
35410	Бичиг хэргийн материал	2,012,635.00	1,579,775.00
35420	Аж ахуйн материал	48,626,753.32	42,347,757.50
35440	Түлш, шатах тослох материал	3,799,700.00	3,225,000.00
35460	Хүнсний материал	30,000.00	-
35600	Мал амьтад	174,690,000.00	195,990,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	32,000,000.00	-
36900	БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө	32,000,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	848,067,363.77	866,902,750.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	848,067,363.77	866,902,750.51
39200	Биет хөрөнгө	835,506,063.77	854,551,450.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	727,174,885.66	849,054,673.66
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(139,975,995.77)	(191,817,952.49)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,801,678.00	152,188,160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(107,300,046.16)	(112,421,026.72)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	278,599,194.00	324,896,841.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(165,173,193.75)	(258,357,564.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,438,496.04	61,607,096.04
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(28,058,954.25)	(30,598,776.59)
39217	Номын фонд	60,000,000.00	60,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	12,561,300.00	12,351,300.00
39301	Програм хангамж	3,810,000.00	3,810,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(3,217,500.00)	(3,427,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,968,800.00	11,968,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,120,481,246.09	1,112,880,730.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	(0.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,120,481,246.09	1,112,880,730.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,120,481,246.09	1,112,880,730.01
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	292,184,453.65	292,184,453.65
51200	Хуримтлагдсан үр дүн	562,117,201.38	554,516,685.30
51210	Өмнөх үеийн үр дүн	440,245,932.65	562,117,201.38
51220	Тайлант үеийн үр дүн	121,871,268.73	(7,600,516.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	266,179,591.06	266,179,591.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,120,481,246.09	1,112,880,730.01

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	562,078,558.46	556,001,028.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,736,978.46	156,976,760.00
1200	Нийтлэг татварын бус орлого	164,736,978.46	156,976,760.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,736,978.46	156,976,760.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,200,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	160,536,978.46	156,876,760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,341,580.00	399,024,268.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,502,480.00	15,521,368.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	40,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	15,575,230.00	3,801,368.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	927,250.00	370,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340,839,100.00	383,502,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,839,100.00	383,502,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	439,620,789.73	563,601,544.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439,620,789.73	563,601,544.08
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,904,869.14	551,507,213.52
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,854,228.00	252,250,690.61
210101	Үндсэн цалин	248,299,403.00	249,450,690.61
210104	Урамшуулал	8,554,825.00	2,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,812,085.41	33,116,961.43
210201	Тэтгэврийн даатгал	21,661,709.16	22,976,326.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,550,194.06	2,551,667.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,026,715.25	2,019,332.28
210204	Ажилгүйдлийн даатгал	506,678.81	502,312.98
210205	Эрүүл мэндийн даатгал	5,066,788.13	5,067,322.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,313,189.00	17,193,603.00
210301	Гэрэл, цахилгаан	1,013,689.00	1,928,903.00
210302	Түлш, халаалт	9,299,500.00	15,264,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,668,325.00	31,676,715.22
210401	Бичиг хэрэг	2,842,200.00	3,305,090.00
210402	Тээвэр, шатахуун	26,205,725.00	15,840,778.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	655,800.00	1,796,051.40
210404	Ном, хэвлэл	72,000.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	812,600.00	524,171.42
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	80,000.00	9,310,624.40
2105	Нормативт зардал	600,000.00	3,080,000.00
210502	Хоол, хүнс	600,000.00	1,430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,650,000.00
2106	Эд хожил, урсгал засварын зардал	-	18,945,100.00
210604	Урсгал засвар	-	18,945,100.00
2107	Томиллолт, зочны зардал	4,244,000.00	3,633,600.00
210702	Дотоод албан томилолт	4,244,000.00	3,633,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,469,832.00	1,103,585.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,313,750.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	229,350.00	249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,088.00	126,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	340,000.00
210807	Газрын төлбөр	87,644.00	138,585.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,943,209.73	190,506,958.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,961,800.00	24,906,585.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	86,981,409.73	165,600,373.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,715,920.59	12,094,330.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,115,920.59	11,694,330.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,115,920.59	11,694,330.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	586,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	122,457,768.73	(7,600,516.08)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	586,500.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	586,500.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	586,500.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	121,871,268.73	(7,600,516.08)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	292,184,453.65	266,179,591.06	562,117,201.38	1,120,481,246.09
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,184,453.65	266,179,591.06	562,117,201.38	1,120,481,246.09
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын жорвуулалтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,600,516.08)	(7,600,516.08)
16	ҮЛДЭГДЭЛ	292,184,453.65	266,179,591.06	554,516,685.30	1,112,880,730.01

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	401,541,580.00	410,379,062.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,200,000.00	3,354,794.00
1200	Нийтлэг татварын бус орлого	4,200,000.00	3,354,794.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,200,000.00	3,354,794.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,200,000.00	3,354,794.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,341,580.00	407,024,268.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,502,480.00	23,521,368.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	40,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	15,575,230.00	11,801,368.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	927,250.00	370,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340,839,100.00	383,502,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,839,100.00	383,502,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	369,209,580.00	383,715,062.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,209,580.00	383,715,062.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,493,659.41	368,785,284.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,871,490.66	252,164,842.60
210101	Үндсэн цалин	212,410,192.66	213,891,859.60
210104	Урамшуулал	8,593,397.00	2,800,000.00
210105	Гэрээт ажлын цалин	35,867,901.00	35,472,983.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,794,822.75	33,116,961.44
210201	Тэтгэврийн даатгал	22,531,795.80	22,976,326.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,318,716.00	2,551,667.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,019,500.00	2,019,332.28
210204	Ажилгүйдлийн даатгал	466,458.50	502,312.98
210205	Эрүүл мэндийн даатгал	4,458,352.45	5,067,322.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,822,389.00	16,618,903.00
210301	Гэрэл, цахилгаан	1,013,689.00	1,928,903.00
210302	Түлш, халаалт	11,808,700.00	14,690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,079,625.00	23,955,959.40
210401	Бичиг хэрэг	2,630,300.00	2,877,130.00
210402	Тээвэр, шатахуун	24,179,525.00	15,840,778.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	655,800.00	1,828,051.40
210404	Ном, хэвлэл	72,000.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,542,000.00	2,510,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	1,400,000.00
210502	Хоол, хүнс	600,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600,000.00
2106	Эд хөшиг, урсгал засварын зардал	4,550,000.00	14,090,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,550,000.00	1,153,500.00
210602	Тавилга	-	540,000.00
210604	Урсгал засвар	-	12,397,400.00
2107	Томилголт, зочны зардал	4,244,000.00	3,633,600.00
210702	Дотоод албан томилолт	4,244,000.00	3,633,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,635,332.00	1,166,685.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,479,250.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	229,350.00	249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,088.00	126,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	403,100.00
210807	Газрын төлбөр	87,644.00	138,585.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,896,000.00	22,637,433.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,896,000.00	22,637,433.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,715,920.59	14,929,777.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,115,920.59	14,529,777.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,115,920.59	14,529,777.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	32,332,000.00	26,664,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	32,332,000.00	26,664,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,332,000.00	26,664,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	32,332,000.00	26,664,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	332,000.00	26,664,000.00
223001	Бусад хөрөнгө	32,000,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=III-V)	(32,332,000.00)	(26,664,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII=III+VI)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>383,502,900.0</b>	<b>375,163,363.44</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	383,502,900.0	375,163,363.4
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	383,102,900.0	374,763,363.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,800,000.0	249,364,842.60
210101	Үндсэн цалин	216,200,000.0	213,891,859.60
210105	Гэрээт ажлын хөлс	36,600,000.0	35,472,983.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,398,000.0	33,116,961.44
210201	Тэтгэврийн даатгал	24,206,000.0	22,976,326.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,548,000.0	2,551,667.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,038,400.0	2,019,332.28
210204	Ажилгүйдлийн даатгал	509,600.0	502,312.98
210205	Эрүүл мэндийн даатгал	5,096,000.0	5,067,322.51
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,030,000.0	16,618,903.00
210301	Гэрэл, цахилгаан	2,030,000.0	1,928,903.00
210302	Түлш, халаалт	15,000,000.0	14,690,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,038,900.0	22,975,151.40
210401	Бичиг хэрэг	2,399,700.0	2,369,130.00
210402	Тээвэр, шатахуун	15,489,200.0	15,459,970.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.0	1,796,051.40
210404	Ном, хэвлэл	900,000.0	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,450,000.0	2,450,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	1,400,000.0	1,400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	800,000.0	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.0	600,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,520,000.0	31,849,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.0	17,049,500.00
210602	Тавилга	3,500,000.0	3,308,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	12,020,000.0	11,492,400.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	5,000,000.0	3,633,600.00
210701	Гадаад албан томиллолт	-	-
210702	Дотоод албан томиллолт	5,000,000.0	3,633,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,266,000.0	1,166,685.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.0	249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,000.0	126,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.0	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.0	403,100.00
210807	Газрын төлбөр	200,000.0	138,585.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,650,000.0	14,637,320.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,650,000.0	14,637,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	400,000.00	400,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	400,000.0	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.0	400,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>383,502,900.0</b>	<b>375,163,363.44</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	383,502,900.0	375,163,363.44
132001	Орон нутгийн төсвөөс	383,502,900.0	375,163,363.44
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>23,521,368.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>15,521,368.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>12,685,921.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,800,000.00
210104	Урамшуулал		2,800,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>980,808.00</b>
210401	Бичиг хэрэг		508,000.00
210402	Тээвэр, шатахуун		380,808.00
210403	Шуудан, холбоо, интeрнeтiйн тeлбeр		32,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		60,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>905,000.00</b>
210604	Урсгал засвар		905,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>8,000,113.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,000,113.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>2,835,447.00</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>2,835,447.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,835,447.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>8,000,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>8,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		8,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>23,521,368.0</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>23,521,368.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,801,368.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	370,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 395.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.9 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.6 хувиар буюу 84.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 243.1 сая төгрөг болж 14.0 сая төгрөгөөр өссөн нь 24.6 сая төгрөгийн мал хүлээн авч бүртгэлд тусгасантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 68.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 82.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 243.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,463.5 сая төгрөг болж 171.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 58.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 125.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 12.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 1,463.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговор олгож авлага үүсгэсэн 3.3 сая төгрөг төлөгдөж хасагдсан, татаас санхүүжилтын авлага 2.8 сая төгрөгөөр үүссэн ба, 2.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,112.9 сая төгрөг болж 7.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 554.5 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 383.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 383.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 383.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урьд оны авлага барагдаж 3.3 сая төгрөг орж, урсгал үйл ажиллагаанд 375.2 сая төгрөгийг зарцуулж 11.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 375.2 сая төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 3.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1.7 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 23.5 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 15.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 8.0 сая төгрөг зарцуулж, 2.8 сая төгрөгийг татан төвлөрүүлж авлагаар тайлагнасан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзлээ.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 110 мэдээллээс 94 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 16 мэдээлэл байна.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 30.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 6.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллаж буй эсэхийг, мөн тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалтыг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 150.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.2 сая төгрөгийн алдааг залруулж, 5.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд шивүүлээгүй 5.2 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн, мөнгөн гүйлгээний тайланд 16.0 сая төгрөгийн залруулга хийсэн.

### 4.2 Төлбөрийн акт

ЗДТГ-т бүртгэлтэй малнаас 30 толгой 2.4 сая төгрөгийн дансны үнэтэй малыг үндэслэлгүйгээр бүртгэлээс хассан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3 дахь заалт "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараахь журмыг баримтална: 1/ худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх; 2/ илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Жилийн эцсийн тооллогоор тулш шатах тослох материалын 3.2 сая төгрөгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, байгаа эсэх нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### 4.3 Албан шаардлага

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 3.3 сая төгрөгөөр тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан орон тооноос 1 орон тоогоор илүү үйл ажиллагаа явуулж байгаа нь Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол "Сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 120.4 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### Орон нутгийн өмчийн газарт:

ИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 9.2-д Бага оврын тракторын нэг бүрийн үнийг 0.47 сая төгрөг гэж оруулсан. Гэвч Баян-Уул сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд 0.47 сая төгрөгийн үнэтэй тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байхад акталсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### 4.4 Зөвлөмж: Зөвлөмж хүргүүлээгүй.

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар	9	150.5	2	21.2		5.6	4	123.7	1	0

/сая төгрөгөөр/